



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 669

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Алтай-Улиастайн эрчим хүчиний систем" төрийн өмчит хувьцаат компанийн охин компани "Богдын голын усан цахилгаан станц" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 13,500,000.00 (арван гурван сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины 2 дахь дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Алтай-Улиастайн эрчим хүчиний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, "Богдын голын усан цахилгаан станц" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ц.Улам-Оргилд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002687

Төрийн ёмчийн бордийн, зохицуулалтын газрын  
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн  
22 дугаар тогтоолын хавсралт

"Богдын голын усан цахилгаан станц" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн  
ундсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, сэлбээгээр худалдах автомашин, механизмын жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арын дугаар	Ашиглал тад орсон он	Нийт гүйлт /км/ он	Балансын үнэ (төгрөг)	Хууримтлагдсан элзэгэл	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Сэлбээгээр ашигтгаснаас олох орлогын хэмжээ (төгрөг)
1	"Галлолер", 52-71 ЗАА, 101713, КМУКР17ВРWW261786	1998/2004	168420	13,500,000.00	13,500,000.00	0	0	1,500,000.00
	<b>Нийт дүн</b>			<b>13,500,000.00 (арван түрвэн сая таван зуун мянган)</b>	<b>13,500,000.00 (арван түрвэн сая таван зуун мянган)</b>	-	-	<b>1,500,000.00 (нэг сая таван зуун мянган)</b>